

## ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛ

## “ГУРАВДАХЬ ЕРТӨНЦ: ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН АСУУДАЛ

Н.Дангаасүрэн, түүхийн ухааны доктор

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1980 оны 11-р сарын тусгай чуулган хөгжиж байгаа ертөнцийн гуравдугаар арван жилийн хөгжлийн хөтөлбөрийг хэлэлцэн баталжээ. Уул хөтөлбөрийн эхний таван жилийн явцыг энэ жил хянан үзэх гэж байна. Хөгжлийн анхны арван жилийн хөтөлбөрийг далаад оноор тогтоон Ерөнхий Ассамблейн 25-р чуулганаар тус тус хэлэлцэн тохирч албан баримт бичгүүд гаргажээ. Баримт бичигт, эдийн засгийн өсөлт, тухайлбал үндэсний орлогын хүн тутамд оногдох дундаж хэмжээгээр “гурав дахь ертөнцийн” улс тус бүрийн хөгжлийн түвшинг тодорхойлох нэгж болгожээ. Хөгжлийн гурван арван жилийн аль алинд үндэсний орлогын жилийн дундаж өсөлтийг 5-7 хувиар төлөвлөсөн нь ихэвчлэн биелэгдэх хандлагатай байна. Гэхдээ, эдийн засгийн өсөлт, хөгжлийн түвшин хоёрт адилтгалын тэмдэг тавьсан хэрэг биш юм. Хөгжлийн ойлголт бол юуны урьд тухайн орны шинж техник, технологи зохион бүтээж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн чадамж буюу товчоор хэлбэл шинжлэх ухааныг үйлдвэрлэх хүчин болгон хувиргаж буй түвшинг тодорхойлоход оршино. Хөгжлийн түвшин нь шинжлэх ухаан, техникийн хөгжилд оруулсан зарчмын шинэ үр өгөөжөөр олон улсын хэмжээнд уул орны эзлэх байрыг тодорхойлно.

К.Маркс “оюун санааны үйлдвэрлэлтэй” харилцан холбоогүйгээр “материаллаг үйлдвэрлэлийн” шинжийг тодорхойлж болохгүй гэдгийг онцлон заасан билээ.<sup>1</sup> Шинжлэх ухаанд өөрсдөө (өөрсдөө гэдэг үгийг онцлов. Н.Д.) нээлт хийж түүний дагуу техник технологи зохион үйлдвэрлэлд нэвтрүүлэх чадамж нь эрдэмтэд, зохион бүтээгчдийн бүтээлч сэтгэлгийн явцад бий болсон “оюун санааны үйлдвэрлэлийн” хөгжлөөр юуны урьд илэрнэ. Дэлхийн зах зээлд хөгжингүй улс гүрэн мөн чанартаа “оюун санааны үйлдвэрлэлийнхээ” бүтээгдэхүүнийг борлуулж байхад, бага хөгжилтэй улс орон “материаллаг үйлдвэрлэлийнхээ” буюу мөн чанартаа материал баялгаа гаргаж байна. Тухайлахад, хөгжингүй орны техник, хими электрон болон бусад бүтээгдэхүүн нь оруулсан түүхий эддээ биш, харин оруулсан оюун санааныхаа ач холбогдлоор ихэвчлэн үнэлэгдэж байна. Өнөөгийн хөгжингүй капиталист ба хөгжиж байгаа улс орны харилцааны эрх ашиг тэгшгүйн ул үндэс үүнд байдгийг нийтээр хүлээн зөвшөөрч байна. Нобелийн шагналт, профессор Франсуа Перру гадаадын капиталын

<sup>1</sup> К.Маркс и Ф.Энгельс. Соц.т 26, ч I, с. 27.

эрхшээлд оршиж буй хөгжиж байгаа эдийн засагт хөгжилтгүй өсөлт осолтой гэдэг дүгнэлт хийжээ.<sup>2</sup> Нөгөө талаар өсөлтгүй хөгжлийн догол талыг бас тэмдэглэжээ. Хөгжиж байгаа олонхи орны эдийн засгийн үйл ажиллагаа нь хөгжингүй капиталист аль нэг гүрний хавсарга шинжтэй оршиж буй өнөө үед эдийн засгийн дан өсөлт уул байдлыг өөрчлөх чадваргүй юм. Харин эдийн засгийн хөгжилт, түүний дагавар болсон өсөлт чухал ач холбогдолтой байна. Хөгжингүй капиталист орон тус бүр “оюун санааны үйлдвэрлэлийн” олон буюу цөөвөр чиглэлээр төрөлжих, дагнах зэргээр дэлхийн капиталист хөдөлмөрийн хуваарьт зохих байр эзлээд хоорондоо” оюун санааны үйлдвэрлэлийн” нэг төрлийн бүтээгдэхүүнийг нөгөө төрлөөр солилцох зэргээр хөгжлийн адил түвшинд, харилцааны тэгш болзолд харилцаж байна.

Иймэрхүү “харилцан хараат байдлыг” хөгжиж байгаа улс гүрэнтэй тогтоох нөхцөл бүрэлдүүлэхэд империалист хүчин бүх талын саад учруулж байна. Социалист болон хөгжингүй капитализмын өмнөх шатанд хамаарагдах 120 гаруй орныг (олонхи бага, багавтар) “гуравдахь ертөнц” гэж нэршжээ. “Гуравдахь ертөнц” түүхэн явцаар социализм, капитализмын аль нэг тийш хуваагдах хандлагаар хөгжиж байна. Үйлдвэрлэх хүчний хөгжлийн байдлыг харгалзан” хөгжиж байгаа орнууд” гэж олон улсын байгууллагын баримт бичигт ихэвчлэн нэрлэх болжээ. Шинжлэх ухааныг үйлдвэрлэх хүчин болгон хувиргах чадамж, тухайлбал” оюун санааны үйлдвэрлэл” төдий л хөгжөөгүй учир эдгээр орны “материаллаг үйлдвэрлэл” ч гэсэн гадаадын техник, шинжлэх ухааны дайвар шинжтэй юм.

“Гурав дахь ертөнцийн” их, бага бүх улсын өмнө “оюун санааны үйлдвэрлэлийн цөөвөр буюу хэсэг чиглэлийг эрчимтэй хөгжүүлэн олон улсын хөдөлмөрийн хуваарьт идэвхтэй байр суурь эзлэх түүхэн зорилго дэвшигджээ. Эдгээр орны дотоодод ажиллах хүчин, байгалийн баялаг, нутаг дэвсгэр бусад нөөц бололцоо бий. Тэдгээр орны шинжлэх ухааны уламжлал, үйлдвэрлэлийн уламжлалыг орчин үеийн бүтээлч сэтгэлгээр баяжуулан шинийг эрж хайх цаглашгүй төлөв байв. Хүн төрөлхтний танин мэдэхүйн сан хөмрөгт орсон зүйлээр үл хязгаарлан эрдэс, биологийн шинэ эх булаг илрүүлэх, микро-электрон, лазерийн шинэ шинэ техник зохион бүтээх, нийлэг шинэ эд боловсруулах, микробиологи, биотехнологи, гарваль зүйн судлалыг хөгжүүлэх, нутгийн мал амьтны биологи-эдийн засгийн судлалыг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн техник, технологийн уламжлалыг орчин үеийн түвшинд дэвшүүлэх гэх мэтчилэн танин мэдээгүйн хязгааргүй уудам зүй тогтолт тийш эрэл хайгуулын жолоог залах нь хөгжингүй шатны гоцлох шинж чанар гэж тоймлож болно.<sup>3</sup>

Харин хөгжлийн стратегийг шинжлэх ухааны үндэстэй боловсруулах, үндэсний нөөц бололцоог тал бүрээс судлах, шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн төрөлжилтийг оновчтой сонгон олох, хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх хугацааг зөв тогтоох зэрэг асуудалд орон тус бүр тодорхой байр сууриас хандаж ялгавартай чиг баримжаа дэвшүүлэх нь мэдээж. Хөгжлийн хурдцын ойлголт энд зохих байр эзлэх шаардлагатай. Үйлдвэрлэх хүчний тодорхой салбарын техник, технологи зо

<sup>2</sup> Francois Perroux A new concert of deveiopment (UNESCO), London: Canberra. P. 36.

<sup>3</sup> Н.Дангаасүрэн. “Гуравдахь ертөнц” эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал. УБ., 41977, 177-р тал.

хион бүтээх чадамжаар гаригийнхаа бусад орныг жагсаасан нэгэн тодорхой хугацааны зураглалд уул орны эзэлсэн байрыг дараачийн хугацааныхтай харьцуулах нь хурдцыг ойролцоо тусгах аргын нэг юм. Түрүүлж яваа оронд хөгжлийн түвшингээр ойртож буй үйл явц онцгой сонирхол татна. “Гуравдахь ертөнцийн” үйлдвэрлэх хүчнийг гадны техник, технологийн үндэс дээр хөгжүүлэх үйл явц эхний хоёр арван жилд ахиц олж олзборлох үйлдвэр төдийгүй боловсруулах үйлдвэр мэдэгдэхүйц олширчээ. Олзборлох үйлдвэрийнхээ бүтээгдэхүүнийг боловсруулах аж үйлдвэр хөгжүүлэхэд үндэсний засгийн газрууд үлэмж анхаарах болсон явдал үр дүнгээ үзүүлж эхэлжээ. Үндэсний эдийн засгийн нэгдмэл цогцолбор бий болгох, эдийн засгийн бүтцэд дэвшилт гаргах талаар ч зарим нааштай алхам хийжээ. Хөгжлөөр дорой эдгээр орныг өрнөдийн хөгжингүй эдийн засгийн хавсарга, эрдэс түүхий эдийн хямд нөөц техник, технологи өндөр үнээр борлуулах зах зээл хэвээр хадгалахын тул империалист улс гүрний явуулж буй хүчтэй даралт, шахалтыг сөрөн хөгжих эгзэгтэй асуудал “гуравдахь ертөнцөд” тохиолдож байна. Өнгөт ба хар төмөрлөг хайлуулах, боловсруулах үйлдвэр, суурь машины үйлдвэр, хими, биотехнологи, электроны зэрэг нэн чухал салбарын аж үйлдвэрийг орныхоо дотоод, гадаад зах зээл, үндэсний эдийн засгийн шаардлагад тохируулан байгуулах гэсэн хөгжиж байгаа улс түмний зүй ёсны эрмэлзлийг олон улсын империализм зориуд эсэргүүцэн саатуулж байна. Энэ мэт хүнд бэрхшээл дундуур үйлдвэрлэлийн зарим салбарт шинжлэх ухааныг үйлдвэрлэх хүчин болгон хувиргаж байгаа улс орны тоо нэмэгдсээр байна.

Хөгжиж байгаа улс орны дэвшүүлсэн хөгжлийн стратегийн эсрэг өрнөдийн “онолчид” наанадаж хоёр зүйлийн шалтаг зааж байна. Хэдэн зуун жилийн хоцрогдлыг арилгахад хэдэн зуун жил хэрэглэнэ гэдэг “баримтлалыг” гаргаж ирдэг. Бодит социализм, капиталист биш хөгжлийн түүхэн замаар хөгжил алгасан дэвшиж буй улс түмний туршлагыг дэлхий даяар андахгүй болсон цагт энэ “баримтлал”-ыг аль ч орон мөрөөдөн дагахгүй нь тодорхой билээ. Өөр нэг шалтаг бол хөгжиж байгаа олонх орны хүн хүч, нутаг дэвсгэр, байгалийн нөөц бага учир өндөр хөгжилд хүрэх боломжгүй гэж номлож байна. Гэтэл Голланд, Бельги, Англи, Франц мэт орон, түүхийн тодорхой үед хүн хүч, нутаг дэвсгэр, байгалийн нөөц зүйрлэшгүй илүүтэй, оюун санааны эртний уламжлалтай улс, бүс, тивээс чухамхүү техник, технологийн шинэ ололтоор давжээ. Империалист хүчин шинжлэх ухаан-техникийн онцгой эрх дархаа хадгалахын тулд шинжлэх ухаан-техникийн хувьсгалыг “хүрч болшгүй” даваа мэтээр хөгжиж байгаа улс түмнийг сүрдүүлэн, тэдний урам зоригийг шантлах гэж хичээх боллоо.

Хөгжиж байгаа бага орны хөгжих боломж нь том улс гүрний адил юм. Капитализмын хуваарьгүй ноёрхлын эрин үе эгнэгт арилж, социализм тодорхойлогч хүчин зүйл болсон орчин үед бага орны бие даан хөгжихөд илүү таатай нөхцөл бүрэлджээ. Тэр ч байтугай эрт, дундад, капитализмын эхний үест бага орон өндөр хөгжилд хүрсэн тохиолдол цөөнгүй бий. Өрнөдийн “баримтлалд” өрнөдийн баримт няцаалтын хувьд Люксембург сонирхолтой байж болох юм. 360 мянган хүнтэй, 3 мянга хүрэхгүй хавтгай дөрвөлжин километр нутагтай боловч тус орны хүн тутамд 16 тонн ган ногдож байхад Бельгид 1,3 т., Холбооны Германд 0,7 т., АНУ-д 0,7 т. байх жишээтэй байна. Люксембург жилд 14-15 сая тонн ган хайлуулах электрон

техник, бусад нарийн багаж үйлдвэрлэх чадвар капиталист ертөнцөд дээгүүр ордог. Сүүлийн үед каучук, нийлэг эд, паалангийн орчин үеийн үйлдвэр хөгжүүлэхэд төмөрлөгөөс хоёр дахин илүү хөрөнгө зарцуулж эхэллээ. Га тутмаас авах ургац, сүү махан бүтээгдэхүүний өгөөжөөр капиталист бусад гүрнээс олон дахин дээгүүр үзүүлэлттэй. Тус орны банкууд Өрнөд Европын томоохон төвд тооцогддог. Энэ бяцхан нутагт Өрнөд Европт байдаггүй онгон байгальтай, зэрлэг амьтад бүхий бүс хүртэл бий. Яахлаараа империализм өөртөө байж болсон шинжлэх ухаан-техник, үйлдвэрлэх хүчний зарим ололтыг бага, буурай оронд бий болох төлөвгүй мэтээр тайлбарлахад хүрсэн нь ойлгомжтой болжээ. Харин жижиг орны хувьд Люксембургийг дэлхийн хөгжиж байгаа бага буурай орны нэг нь ч “хөгжлийн загвар” болгон авч буй баримт гараагүй юм. Капитализмын бүхий л цөхрөл Люксембургийг нөмөрчээ. Улс дамнасан нийгэмлэгүүд, империалист түрэмгий дайны эвсэл Люксембургийн нөөцийг нь шавхаж байна. Иймээс хөгжиж байгаа бага орны өндөр хөгжилтэй ирээдүй нь юуны урьд социализмд хамаарагдана. Бага, дунд, том орны алинд боловч нийтлэг хэтийн төлөв бол социализм, социализмыг баримжаалсан хөгжил болох нь улам тодорхой нотлогдох боллоо.

“Гуравдахь ертөнцийн” хөгжилд японы “загвар” тустай гэж өрнөдийн “онолчид” давтан дурддаг. Хөгжиж байгаа улс түмнийг дэлхийн капиталист аж ахуйн хүрээнд хадгалахад энэ мэт “загвар” хэрэгтэй болжээ. Социализмын туршлагыг нэвтрүүлэхгүй байхад үнэн хэрэг дээр зориулагдсан “хөгжлийн загвар” тэр энэ орны “гайхамшиг” гэх зэрэг шуугиан дэгдээсэн “баримтлал” дэвшигдээд удалгүй уул орны нийгмийн доголдол, үргэлжийн хямрал, үйлдвэрлэх хүчний зогсонги байдал зэрэг зүйл бүрийн баримтад няцаагдан нурсаар ирлээ. Япон нэг зуун жилийн дотор орчинжсон нь маргаангүй баримт юм. Зуу гаруй жилийн тэртээх Японы эдийн засагт эгэл аргаар эрхэлсэн хөдөө аж ахуй голчилж, гар урлал дараачийн байрыг эзэлж байлаа. 1870-аад оны сүүлчээр хүн амын 80 орчим хувь нь хөдөө аж ахуй эрхлэн үндэсний орлогын 65 хувийг гаргаж байжээ.<sup>4</sup> Феодалын Япон нь тэр үеийн Англи, Франц, Герман, АНУ, Хаант Орос, Голланд, Бельги мэт капиталист аль нэг гүрний колони болоогүйг Японы эрдэмтэд голдуу үндэсний нэгдэл, төвлөрсөн захиргааны бие даасан үйл ажиллагаатай холбож тайлбарладаг. Нөгөө талаар хүчирхэг гүрнүүдийн зөрчлийг овжин ашиглан хэн нэгний нь эрхшээлд оролгүй байж шинжлэх ухаан-техникийн мэдлэгийг харьцангуй бага болзлоор оруулсан гэж үздэг. Орчин үед улс дамнасан нийгэмлэгүүд, империалист улс гүрний зүйл бүрийн эвсэл нь тэдний дотоодын зөрчлөөс илүү хүчтэй байгаа онцлогийг харгалзахгүй байж болохгүй. Нөгөө талаар шинэ колониололын сөрөг стратеги, тактик нь зуун жилийн өмнөх байдлаас эрс өөр болжээ.

Япончууд үндэсний соёл, орчин үеийн шинжлэх ухаан-техникийн ололтыг хосолсон гэж олонтой бичдэг. Энэ бол хөгжингүй бараг орон бүрийн шинж билээ. Тус орон техник, шинжлэх ухааны өнөөгийн түвшинд хүрэхдээ: нэгд, гадаадын техник авч хэрэглэсэн; хоёрт, гадаадын техникт сэлбэг хийхээс эхлэн дууриан үйлдэх болсон; гуравт, гадаадын техникийг сайжруулан үйлдвэрлэх болж, улмаар цоо шинийг зохион бүтээх болсон ажээ. Энэ бол хожим хөгжсөн улс бүрд тохиолдож буй нийтлэг үзэгдэл юм. Япон улс хэдий эрдсийн нөөц харьцангуй

<sup>4</sup> Japan in transition. (One Years of Modernization) Tokyo, 1975, p 2

бага, нутаг дэвсгэр явцуухан боловч шинжлэх ухаан-техникийн сэтгэлгийн нөөцийг үлэмж арвижуулжээ.<sup>5</sup> Гэвч нийгмийн байгууллын мөн чанараар “Японы загвар” шинэ тулгар орны эрмэлзэх ирээдүйн жишээ болж чадахгүй билээ.

Учир нь империалист жанжлах бодлогын мөн чанар нь шинэ хөгжиж байгаа оронд өөрийн “амьдралын хэв маяг”, “хөгжлийн загварыг” тулган хүлээлгэж “дагуул улс орны бүс”, “нөлөөний хүрээ” бий болгох оролдлогоор илрэн харагдаж байна. Бодит байдалд орон бүр байгаль орчин, үйлдвэрлэх хүчин, оюун сэтгэлгийн хөгжлийн уламжлал, нийгэм-эдийн засгийн дэвшлийнхээ үйл явцаар өөртөө тохирсон “амьдралын хэв маяг”, “хөгжлийн загвар” бий болгодог, цаашид ч бий болгоно.

Империализм, шинэ колоничлол нь “гуравдахь ертөнцийн” улс орныг хөгжингүй түвшинд хүрэх бүх зам, түүний дотор өндөр хөгжилтэй капитализм байгуулах замыг хүртэл боогдуулагч хүчин зүйл болжээ.

Хөгжлийн дотоод нөөц бололцоог судлан илрүүлэх, шинэ байр сууринаас үнэлж үзэх асуудал “гуравдахь ертөнцийн” улс түмний онцгой чухал зорилт болжээ. Хөгжлийн өвөрмөц эх үүсвэр орон бүрт бий. Гагцхүү түүнийг олж дэмжих, таатай угтвар нөхцөлийг бүрэлдүүлэхэд хамаг учир оршино. Орон бүрийн тэрхүү давтагдашгүй ундраа нь түүхэн тодорхой шатанд хөгжлийн цаглашгүй төлөв болж хувирна. Капиталист хөгжлийн явцаас ч үзсэн, хөгжлийн эхлэл үл анзаарагдах зүйлээс зарчмын шинэ нээлтэд хүрсэн баримт олонтой. Альберт Эйнштейн харьцангуйн онол нээсэн нь физикийн ухаанд эргэлт боллоо. Исаак Ньютоноос хойших физикийн бүх ололтоор энэ үйл явдал бэлтгэгдсэн нь ойлгомжтой боловч А.Эйнштейны амьдарч байсан Герман Швейцари хоёр энэхүү нээлтийг гарснаас хэзээ хойно түүнд анхаарал тавьжээ. А.Эйнштейн амьдралын гачигдалд нэрвэгдсэн ганцаардмал байдалд уул нээлтийг хийжээ. Английн Кембриж гэдэг эрдмийн хотхоныг дэлхий даяар андахгүй. Тэндэх Кавендишийн лаборатор нь профессор Резерфордын үед онцгой алдаршжээ. Шинэ Зеландаас Резерфорд гэх мэтчилэн авьяастай физикчид урсгалаар цугларч шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. Зөвлөлтийн нэрт эрдэмтэн П.Л.Капица, Ю.Б.Харитон нарын дуртгал энэ талаар их сонирхол татаж байна. Энэ лаборатор гойд багажийн ид хүчээр биш, харин судлагчид нь гүнзгий бодолд хөтлөгдөн ажиллаж энгийн багаж, хялбар аргаар нэр амжилтад хүрсэн гэж тэд бичжээ. Хэрэв сайн бодож чадвал харьцангуй жирийн аргаар бага зардал гарган ямар ч төвөгтэй асуудлыг шийдэж болно гэдэгт Ю.Б.Харитон, П.Л.Капица нар тэр үеэс итгэжээ. Нельс бор нь Данийг физикийн өндөр түвшинд хүргэлээ. Судалгаа, зохион бүтээгчдийн бяцхан хамтлаг, ганц хоёрхон сэтгэн бүтээгч ч шинжлэх ухаанд аварга хувь нэмэр оруулан чадах ажээ. Ингэхлээр ямар ч бага улсын хөгжихөд хүн цөөдөх, нутаг давчдах мэтчилэн шалтаг заадаг өрнөдийн “онолд” шинжлэх ухааны үндэслэл байхгүй юм.

“Гуравдахь ертөнцийн” улс түмний үйлдвэрлэх хүчин, шинжлэх ухааны хөгжлийн хэдэн мянган жилийн түүхийг эргэн харсан ч цаглашгүй олон нээлт, туршлага бий. Физик, математик, астрономи, хими, биологи, удамшил зүй, анагаах ухаан, соёл урлагаар хүн төрөлхтөний мэдлэгийн бүх санд хувь нэмрээ оруулаагүй ард түмэн “гуравдахь

<sup>5</sup> Kenzo kiga Charaherictics of Japan's Economic Growth Budapest 1969 p 13

ертөнцөд” байхгүй гэж баттай хэлж болно. Сүүлийн гурван зуун жилийн турш хошуучилсан Өрнөд Европын шинжлэх ухаан-техникийн ололт ч гэсэн зөвхөн европ дахин төдийгүй манай гаригийн нийт хөгжлийн үр дагавар, үргэлжлэл гэж үзэж болно. Хөгжиж байгаа ертөнцийн соёлын уламжлалд ихэвчлэн хамаарагдах Ази болон бусад тивийн нүүдэлчид, бэлчээрийн мал аж ахуй голчлон эрхлэгчдийн соёл иргэншлийг нэхэн судлах ажилд хангалтгүйн гадна “Европ төвийн” болон “Хятад төвийн” зэрэг харгис дээрэнгүй үзлийн байр сууриас бичсэн зүйл цөөнгүй юм. Иймээс ертөнцийн энэ хэсгийн соёл иргэншлийг шинэ үзэлт, шинэ байр сууринаас судлах явдал хөгжлийн чухал нөөцөд зүй ёсоор орно.

Хөгжиж байгаа улс тус бүрийн өмнө шинжлэх ухааны стратеги, тактикийг төлөвлөх, улам боловсронгуй болгох зорилт тулгарчээ. Шинжлэх ухааны хөгжлийн тактик нь нааштай шийдвэрлэгдэх нэлээд үндэслэл бүхий асуудалд аргачлал боловсруулахад холбогддог бол стратеги нь шийдвэрлэх асуудлыг тууштай сонгон тодорхойлоход юуны урьд хамаарагдана.<sup>6</sup> Эдийн засаг, нийгмийн хойшлуулшгүй эрэлт хэрэгцээг онож тусгасан асуудлыг шилэх хялбаргүй. Гэвч, энэ бол хөгжлийн чухал баталгааны нэг хэсэг юм. Судалгааны явцад хувь хүний бүтээлч сэтгэлэг, эрдмийн хамтлагийн нэгдмэл үйл ажиллагаа хоёрыг хослох онцгой ач холбогдолтой байна. Шинжлэх ухаанд хэвшил болсон ойлголтыг эвдэх, шинээр шийдвэрлэх асуудлыг олж илрүүлэх, ухамсаргүй үйл явцаас ухамсартайд шилжих нь зарчмын шинэ асуудал урган гарах буюу шийдвэрлэгдэх үе шат болох цөөнгүй. Тодорхой асуудлыг хэд хэдэн төрлийн шинжлэх ухааны төлөөлөгчид тал бүрээс хамтран судалснаар хэд хэдэн зүйлийн нээлтэд нэгэн зэрэг хүрэх тохиолдол ч гарчээ. Физик, биологи, химид энэ нэгдмэл ажиллагаа өргөн дэлгэр үзэгдэл болжээ. Байгаль ба нийгмийн ухааны хамтын судалгаа бас өргөжлөө. Шинжлэх ухааны төрөлжилт олширч, нарийсахын зэрэгцээ шинэ шинэ шинжлэх ухаан бий болсоор байна. Энэ зууны анхны хорин жилийн эцсээр хүн төрөлхтөн нийгэм-эдийн засгийн хөгжлийн шинэ эринтэй золголоо. Шинжлэх ухаанд гарсан том том нээлтийг дагаж хүн төрөлхтөний хувь заяанд тодорхойлохуйц эргэлт гарсаар байна. Европын соёл иргэншил дорно дахиныхаас давж гарсан нь тэд үйлдвэрлэх хүчний хөгжилд техникийн ололт, шинжлэх ухаан хэрэглэсний шууд үр дүн гарлаа. Техник, шинжлэх ухааны хоцрогдлыг арилгахгүйгээр техник, шинжлэх ухааны хараат байдлыг эвдэх боломж төгс бүрэлдэхгүй юм. Иймээс “гуравдахь ертөнцийн” хөгжлийн стратегийн зангилгаа асуудал нь техник, технологийн өндөр хөгжлийг хангах нийгэм-эдийн засгийн таатай нөхцөлийг бий болгоход оршино.

Ирэх хорин нэгдүгээр зууны “гуравдахь ертөнцийн” бүх орон бага, буурай гэлтгүй хөгжингүй түвшинд дэвшин “оюун санааны үйлдвэрлэлийн” эрин болгохыг зорьж байна. Ирэх зууны төлөвийн төсөөлөл, бүртгэл, тооцоог олонхи орны шинжилгээний төвүүд нэгэнт гаргажээ. Үйлдвэрлэх хүчний хөгжил, зах зээлийн судалгаа нь бүс, тив, гаригийнхаа төлөвтэй нягт уялдах шаардлагатай байна. Орчин үеийн эдийн засгийг төлөвшүүлэн бүрэлдүүлэх, аж үйлдвэржилтийн хамгийн шаардлагатай хэд хэдэн салбарыг онож хөгжүүлэх, шинжлэх ухаан-техникийн тулгуурлах гол гол салбарыг сонгон зонхилуулах замаар олон улсын хөдөлмөрийн хуваарьт тэгш эрхтэй оролцох үндсийг

<sup>6</sup> J. Bernal Science in history London 1954 p 22

хангах нь хөгжлийн стратегийн биелэлтэд бодит суурь болно. Хөгжингүй улс гүрэнтэй эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хөгжлөөр мөр зэрэгцэхэд хөгжлийн стратегийн агуулга оршино.

Үндэсний эдийн засгийн стратеги нь дан ганц шинжлэх ухаан-техникийн дэвшилтээс шинжлэх ухаан-техникийн хувьсгалд дэвших зорилгоор хязгаарлагдвал түүнийг хэрэгжүүлэх нийгэм-эдийн засгийн нөхцөл бүрэлдэхгүйд хүрнэ. Шинжлэх ухаан-техник, эдийн засгийн хөгжлийг ухамсартай чиглүүлэн залахаар барахгүй нийгмийн дэвшлийг ч ухамсартай хөтлөх шаардлагатай болжээ. Нийгэм-эдийн засгийн үйл явцыг урсгалаар орхивол хөгжлийн стратеги нь нийт үндэстнийг дайчлан чиглүүлэгч хэрэглүүр болж чадахгүй. Хэрэв “гуравдахь ертөнцийн” хөгжлийг урсгалаар, зарим шинэчлэлтийн төдий алхмаар хязгаарлавал шинжлэх ухаан-техникийн дэвшил, үйлдвэрлэх хүчний хөгжил, хөдөлмөрчдийн соёл-ахуйн түвшинд гарах ахиц ирэх зуунд ч гэсэн базаалтай дүнд хүрэхгүйг өрнөдийн судалгааны нэртэй төвүүдэд гарсан судалгааг иш татан тэмдэглэж болно. Тэдний үзэж байгаагаар бол хөгжингүй капиталист ба хөгжиж байгаа улс орны хөгжлийн зөрөө ирэх зуунд ялихгүй багасч харин хорин хоёрдугаар зуунд нэлээд ойртох жишээтэй дүгнэлтэд хүрчээ.<sup>7</sup> Энэ бол империалист улс гүрэн халуун цөмийн дайнд галзуурсан мэт бэлтгэж, сансрыг дайны талбар болгоход асар их хөрөнгө, оюун ухааны нөөцийг шавхан, байгаль орчныг газар сайгүй бүрэлгэн сүйтгэж хордуулан, нөгөө талаар хүн төрөлхтөний тэн хагасаас давж гарсан хөгжиж байгаа орны олон түмнийг шулан мөлжиж өлсгөлөн, гуйланчлалын туйлд нэрвэгдүүлсэн гунигт байдлын тусгал ч байж болно. Товч тэмдэглэхэд өрнөдийн эрдэмтэд хөгжиж байгаа улс түмний ирээдүйг олон улсын капиталын эрхшээлд түүний бүх доголдолд нэрвэгдсэн хараат капитализмын цөхөрдмөл байдалд авч үзжээ. Энд хөгжиж байгаа ертөнцийн нийгэм-эдийн засагт гарах үндсэн эргэлт, дэлхийн хүчний харьцаанд ирээдүйд гарах өрнүүн төлөв тусгагдсангүй. Харин түүхийн хүрд зүй тогтлоороо урагшилсаар байна.

Хөгжлийн стратегийн зорилгод “гурав дахь ертөнцийн” улс түмэн улам өргөн хамрагдах болсон өнөө үед тэдгээр орны дотоод дахь нийгэм-эдийн засгийн иж бүрэн дэвшилт өөрчлөлт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна. Дэвшилт дэглэм бүхий улсын дотоодод эдийн засгийн улс, хоршооллын салбар зонхилж, шинжлэх ухаан-техникийн дэвшилт хурдасч байна. Дотоод нөөц бололцоог төвлөрүүлэн чиглүүлэх явцад төлөвлөгөөт удирдлагын арга, удирдлагын шинжлэх ухаан нэвтэрч байна. Төлөвлөлтийн тогтолцоонд загварчлал, шугамын программчлалын аргыг хөгжиж байгаа ертөнц хэрэглэж эхэллээ. Хөгжлийн ерөнхий зураглал боловсруулах, аж үйлдвэрийн байршлыг тодорхойлох, хөрөнгө оруулалтын үр ашгийн тооцоолол, орон нутгийн тэнцвэртэй хөгжлийн асуудлыг нийт үндэстний эдийн засгийн бүтэцтэй нягт уялдуулан шийдвэрлэхэд эдийн засаг-математикийн аргыг нэлээд орон хэрэглэж байвч ихэвчлэн сорилтын шатанд байна. Иймээс хөгжлийн стратеги, тактикийн шинжлэх ухааны үндэслэлийг тууштай боловсруулах, түүнд эдийн засаг-математикийн аргачлалыг өргөн нэвтрүүлэх явдал онцгой ач холбогдолтой юм. Өргөн олны

<sup>7</sup> J.Tinbergen Reshaping the international Order A report to the Club of Rome, New York, 1976. p.182-184 H. Kahn. W. Brown, L. Martel The Next 200 Years, New York, 1976, p. 48-49 E. Laszlo et al. Goals for Mankind. A Report to the club of Rome, New York, 1977. p. 299-302

амьдрал, соёлд үндсэн өөрчлөлт гарсан нь улсаа орчинжуулах чухал зүйл боллоо. Эрин үеийн нийгмийн дэвшилтийн агуулга нь төрийг жолоодох үйлсийг хөдөлмөрийн олонд жинхэнэ ёсоор эдлүүлэх, тэдний эрх ашгийг шинжлэх ухааны үндэслэлтэй тусгасан бүрэн эрхт дотоод, гадаад бодлого явуулахад оршино. Иргэн бүрийн бүтээлч сэтгэлэг, авьяас зүтгэлийг оргилуулах нөхцөлийг бүх талаар бүрэлдүүлэх хойшлуулшгүй асуудал нэгэнт тулгарчээ. Уул орны нийгмийн шинж чанараас шалтгаалан хөгжлийн гадаад нөөц, гадаад хүчин зүйлд хандах байр суурь бас тодорхойлогдох болжээ. Хэрэв хөгжиж байгаа орон тэгш эрхийн зарчмыг тууштай баримтлахгүй шинэ колонилогчдын хараат байдалд автагдахад хүрвэл уул орны дотоод дахь нийгэм эдийн засгийн дэвшилт буурна. Шинэ колонилогчдын эрхшээлд орсон нөхцөлд эдийн засгийн улс, хоршооллын салбар ч цөлбөн хоослуулах үүрэг гүйцэтгэх тохиолдол цөөнгүй. Шинэ колонилогчдын эрхшээл нөлөөнд хийгдсэн соёлын зарим ахиц, мөн чанартаа империализмын оюун сэтгэлгийн боолчлолд оруулах зэвсэг болох бий. Иймээс олонх хөгжиж байгаа орон социалист ертөнцтэй харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхэд үлэмж анхаарал тавих болсон нь гайхалтай биш юм. Михайл Сергеевич Горбачев: “Тэдгээр улс бол бат бэх энх тайвны төлөө, улс түмний хоорондын сайн сайхан, шударга харилцааны төлөө тэмцэлд бидний нөхөр түнш болж байдаг”<sup>8</sup> гэсэн билээ. Үүний хамт хөгжиж байгаа улс орны хооронд бүрэн эрхт байдлаа харилцан дэмжсэн найрсаг зарчимд тулгуурлан хамтын ажиллагаа хөгжүүлэх нааштай төлөв бий болжээ.

Социализмын давуу талыг амьдрал дээр өөрсдийн ажиглалтаар ойлгох явдал “гуравдахь ертөнцийн” улс түмэнд хэмжээлшгүй ач холбогдолтой болжээ. Хөгжиж байгаа ертөнцөд социализмыг баримжаалсан улс улам нэмэгдэж буй баримт үүнийг баталж байна. Нийгмийн бүхэл хэлбэршил алгасч үйлдвэрлэх хүчний дундад зууны түвшингээс орчин үеийн шинжлэх ухаан-техникийн ололт, мөлжлөггүй нийгмийн байгуулалд дэвшин орсон БНМАУ-ын туршлага “гуравдахь ертөнцийн” анхаарал татаж байна. Хөгжиж байгаа ертөнц бага орны хувь заяаг онцгой сонирхон буй өнөө үед БНМАУ нь ЭЗХТЗ-ийн гишүүн хөгжингүй орнуудтай эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хөгжлийн төвшингөөр мөр зэрэгцэх зорилгыг социалист хамтын нөхөрлөлийн бүх орны халуун дэмжлэгээр дэвшүүлсэн явдал олон улсын нэн чухал ач холбогдолтой үйл хэрэг боллоо.

Монголын ард түмэн 21-р зууны босгыг алхахдаа шинжлэх ухаан-техникийн хөгжингүй түвшинд байх зориг эрмэлзлээр дүүрэн байна. Хөгжлийн янз бүрийн шатнаас дэвшилт хийсэн зөвлөлтийн олон үндэстний ард түмний ололт, хөгжиж байгаа улс түмэнд зоригжуулагч жишээ юм. Зөвлөлтийн ард түмний туршлага бол юуны урьд далайцтай санаачилга, хүчиндээ итгэх итгэл, тэсвэр хатуужил, баатарлаг хөдөлмөрийн хослол, урьд нь хүний мөр гараагүй чиглэлээр нийгмийн байгуулал, шинжлэх ухаан, үйлдвэрлэх хүчний хөгжилд гаргасан их хувьсгал, аварга үйл явдал мөн. Хэрэв бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэн хүч чадлаа нэгтгэн дайчилбал аугаа ихийг бүтээж чадна гэдэг найдварыг хөгжиж байгаа улс түмэн ЗХУ, социалист ах дүү улс орны туршлагаас олж харж байна. Үүний хамт “гуравдахь ертөнцийн” бүх орны бүрэн эрхт байдал, хөгжил дэвшилд туслах найдвартай холбоотон нь

<sup>8</sup> М.С.Горбачевын хэлсэн үг “Үнэн”, 1985 3.13

бодит социализм мөнийг тэд амьдралын явцад танин мэдсээр байна. Гэтэл “гуравдахь ертөнцийн” алив улс гүрний хөгжлийн стратегийн эсрэг империалист гүрнүүд тус тусын сөрөг стратеги, тактикийг аль хэдийнээ боловсруулаад хэрэгжүүлж эхэлжээ. Энэхүү сөрөг стратеги, тактикийг хэрэгжүүлэх үйл явц нь эдийн засгийн түрэмгийлэл, үзэл суртлын түрэмгийлэл, соёлын түрэмгийлэл, технологийн түрэмгийлэл, тэдгээрийг дагалдсан эдийн засгийн шинэ колоничлол, үзэл суртлын шинэ колоничлол, соёлын шинэ колоничлол, технологийн шинэ колоничлол мэтчилэн зүсэн бүрийн түрэмгийлэл, шинэ колоничлолоор илрэн гарч байна.

Улс хоорондын бүрэн тэгш эрхт харилцааны хэм хэмжээг зөрчсөн алив илрэл нь улс түмний хөгжил дэвшил, найрамдал, энх тайванд хохирол учруулж байна. Тэгш эрхийн зарчмыг эдийн засаг, улс төр, үзэл суртал, соёлын бүх хүрээнд нэвтрүүлэх шударга санаачилгыг хөгжиж байгаа ертөнцийн ард түмэн зүй ёсоор тавьж ирсэн юм. Үүний дотор улс хоорондын мөлжлөгийг таслан зогсоох шаардлага нь НҮБ-ын албан ёсны шийдвэр "эдийн засгийн шинэ" дэг журамд" тусгалаа олжээ. Энэ зарчмыг зөвхөн үгээр биш, жинхэнэ үйл хэрэг болгон дагаж мөрдөхийг империалист улс гүрэнд улам хурцаар шаардах болов. Бүрэн тэгш эрхийн зарчимд тулгуурлан худалдаа-эдийн засгийн харилцан ашигтай харилцааг хөгжүүлэх, техник-шинжлэх ухааны ололтыг хожим хөгжиж байгаа улс түмэнд эзэмшүүлэхэд харамгүй хандах нь нийт хүн төрөлхтний ашиг тусад бүрэн нийцсэн билээ. Шинжлэх ухаан-техникийн талаарх империалист сөрөг стратеги, технологийн шинэ колончлолын үндсэн агуулга нь хөгжиж байгаа орны энэ талын хоцрогдлыг улам гүнзгийрүүлэхэд чиглэжээ. Хөгжингүй капиталист улс гүрэн шинжлэх ухаан, техникт шинэ нээлт, бүтээл гаргах тутам тэднийг дагалдан хөгжиж байгаа буурай орны хоцрогдол тэр хэмжээгээр ихсэнэ. Ийнхүү бага хөгжилтэй орны техник, технологийн хараат байдал улам гүнзгийрч, үндэсний технологийн зарим эхлэл өрсөлдөх чадвараа алдан, хөгжингүй капитализмын техник, технологийн зах зээл болж үлдэхэд хүрнэ. "Оюун санааны үйлдвэрлэлийн" талаар давуу байдлаа алдахгүй гэсэн империалист харгис, хэрцгий бодлого энэ мэтчилэн хэрэгжиж байна.

Эдийн засгийн шинэ колоничлолын хэлбэр нь худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагаа, санхүү зээл, техник, мэргэжилтний туслалцаа, хувь нийлүүлсэн нийгэмлэгүүдийн жирийн дүр төрхөөр халхлагдан идэвхжих боллоо. Түүгээр ч барахгүй буцалтгүй тусламжийн агуулгад нуугдах нь ч цөөнгүй юм. АНУ, империалист бусад гүрэн эрдэс, байгалийн бусад баялгаа дарж нөөгөөд хөгжиж байгаа ертөнцийн эрдэс, баялгийг ашиглахад үлэмжхэн техник мэргэжилтэн санхүү бусад хөрөнгө хүчээ дайчилж буй бодлогын мөн чанарыг ойлгоход тийм ч хэцүү биш юм. Зөвхөн энэ зууны үлдсэн хугацаанд ойлгоход тийм ч хэцүү биш юм. Зөвхөн энэ зууны үлдсэн хугацаанд дэлхийн аж үйлдвэрийн зарцуулах өнгөт ба хар төмөрлөг зэрэг нийт эрдэс нь хүн төрөлхтний соёл иргэншлийн бүх үеийнхтэй тэнцэнэ гэж эрдэмтэд үзэж байна. Ирэх зуунд эрдсийн эрэл хэрэгцээ хэмжээлшгүй өсөхтэй хамт өнөөгийн байдлаар олдох эрдсийн нөөц эрс багасаад, нутагшсан буюу үлэмж хольцтой мэтчилэн нэн төвөгтэй ажиллагаа шаардах эрдсийн ялгах, боловсруулах техник технологи зохион бүтээх төдийгүй, далайн гүн, сансрын уудамд олзворлох, боловсруулах үйлдвэр, судалгааг хөгжүүлэх асуудал ч дэвшигдэх нь мэдээж. Хөгжингүй капиталист улс гүрний шинжилгээний төвүүд энэ асуудлыг аль хэдийнээ тооцоолж, хөгжиж байгаа ертөнцийн эрдэс, баялгийн

талаар явуулах тусгай бодлогоо боловсруулжээ. Улс үндэстэн дамнасан нийгэмлэгүүд “гурав дахь ертөнцийн” эрдсийг яаравчлан шавхаж буй нь тэдгээр бага хөгжилтэй орны ирээдүйн аж үйлдвэржих үндсийг эвдлэн сулруулах империалист сөрөг стратегийн салшгүй хэсэг мөн. Өндөр хөгжилтэй, биеэ даасан цогцолбор бүрэлдүүлэх чухал нөхцөл бол эрдсийн иж бүрэн нөөц юм. Төрөл бүрийн эрдсийн нөөцийн тэнцвэрийг алдагдуулах нь аж үйлдвэрийн бүрэн бүтэц, тогтолцоог бүрэлдүүлэхэд ноцтой бэрхшээл учруулна. Иймээс эрдсээр хомсдосны дараах аж үйлдвэржих бодлого утга чанараа алдахад хүрнэ. Шинэ техник, технологи тэр байтугай эрдэс, байгалийн бусад баялгийн талаар ирээдүйд хараат байдалд орж мэдэх аюулаас сэрэмжлэх асуудал өнөөгийн хөгжлийн стратегийн зүй ёсны зорилт болжээ. Аж үйлдвэрийн багаж төхөөрөмж үйлдвэрлэх, цогцолбор судалгааны бүхэл тогтолцоо бүрэлдүүлэх гэсэн хөгжиж байгаа улсын бодлогыг империалист гүрэн элдэв аргаар эсэргүүцэж байна. Дэлхийн капиталист аж ахуйн хөдөлмөрийн үндсэн хуваарийг хөгжингүй “төв” хоцрогдсон “хязгаар” болгосон урьдах байдлыг хэвээр хадгалахад эдийн засгийн шинэ колоничлолын агуулга оршиж байна. Цэрэг-улс төрийн илэрхий түрэмгийлэл олон нийтийн эсэргүүцлийг илүү хүлээх байдлыг харгалзан түрэмгийллийг бусад олон хэлбэрээр өргөжүүлэх боллоо.

Соёлын түрэмгийлэл, соёлын колоничлол нь алив улс түмний соёлын харилцааны хэлбэрээр нэвтэрч, улмаар уул орны үндэсний соёл, урлаг, утга зохиолын уламжлалыг шахан зайлуулах, эцэст нь тухайн империалист гүрний соёл, урлаг, утга зохиолын ноёрхлыг ханган бусад улс түмний соёлтой танилцах хэм хэмжээг хүртэл алдагдуулж байна. Хөгжиж байгаа улс орон боловсролын түрэмгийлэлд нэрвэгдэж буй баримт цөөнгүй байна. Бага хөгжилтэй орны бэрхшээлийг далимдуулан өсвөрийн үеийнхэнд өөрийгөө сурталчилсан сурах бичиг нэвтрүүлэх, уул орны байгаль, нийгмийн судалгаанд тулгуурласан сурах бичиг зохиоход саад хийх, дэлхийн болон үндэсний шинжлэх ухаан, соёл, үйлдвэрлэх хүчний мэдлэг дэлгэрүүлэхэд бэрхшээл учруулах тохиолдол төв, баруун африкийн зарим оронд үзэгдэж байна. Империалист мэдээллийн түрэмгийлэл нэн идэвхжиж байна. Хөгжингүй капиталист улс бүр “гуравдахь ертөнцийн” олон нийтийн ухамсрыг өөртөө ашигтайгаар залуурдахыг оролдож байна. Үзэл суртлын түрэмгийллийн агуулга нь империализмын мөн чанарыг урвуугаар тайлбарласан “онолын” элдэв баримтлалаар хүмүүсийн ухамсрыг төөрөлдүүлэхэд чиглэжээ.

Үзэл суртал, соёл, мэдээллийн түрэмгийлэл нь бүхэлдээ хөгжиж байгаа орны олон түмний биеэ дааж сэтгэн бодох чадварыг нь мохоох, хүчиндээ итгэх итгэлийг нь алдагдуулах, үндэсний нэгдэл, бахархлыг нь эвдэн сарниулах явцаар тухайн империалист гүрний үзэл бодлогыг бишрэн дагагчид, дуулгавартай биелүүлэгчид болгоход чиглэж байна. Иймээс оюун сэтгэлгийн боолчлолоос ангижран жинхэнэ чөлөөт сэтгэлэг, шинжлэх ухааны сэтгэлгийг хөгжүүлэх, империализмын эсрэг дэвшилт үзэл суртал, соёл, мэдээлэл, шинжлэх ухаан, эдийн засгийн сэтгэлгээг сэргүүлэн тавих явдалд хөгжиж байгаа улс түмэн зүй ёсны анхаарал тавьж байна.

Империалист түрэмгийллийн аюултай хэлбэрийн нэг нь хөгжиж байгаа оронд шургалуулсан тагнуул, хорлон сүйтгэгчид юм. Улс үндэстний дотоодын задрал, хагарал, эдийн засаг, оюун сэтгэлгийн доройтол ихэвчлэн гаднын сөрөг хүчний үйл ажиллагааны илрэл

харийн илэрхий ноёрхлын угтвар болсон далдын хорлон бусниулах бодлогын уршиг юм. Энэхүү далдын хүч нь бага хөгжилтэй орны доторхи эрх тушаал хөөцөлдөгчид, хувиа хичээгчдийг юуны урьд тэтгэн ашиглаж байна. Гаднын хүчтэй дэмжлэгт түшиглэсэн бүлгүүд нийгмийн дотор чухал байр суурийг эзлэн эх оронч дэвшилт хүчний үйл ажиллагаа, түүний дотор шинжлэх ухаан, техникийн хөгжлийн саатуулах үйлдлийг урьдаас боловсруулсан төлөвлөгөөний дагуу өдүүлсээр байна. Тэд эх оронч дэвшилт зүтгэлтнийг нийгмийн тайзнаас зайлуулах, өөртөө ашигтай хүчнийг бэхжүүлэхийн тулд цуурхал тараах, гүтгэн хилсдүүлэх, айлган сүрдүүлэх, тийм алхмууд бүтэлгүй болоход хүрвэл амь насыг бусниулахаас ч буцахгүй байна. Энэтхэгийн нэрт зүтгэлтэн Индира Гандийн амь насыг бүрэлгэсэн гунигт явдлыг мэдэх билээ. “Гуравдахь ертөнцийн” аль нэгэн орны нутаг дэвсгэр, ус агаарт хорт сорилт, туршилт үйлдэх, бактерлогийн элдэв нян тахал тарааж турших, хордогдсон буюу хортой хүнсний зүйл нэвтрүүлэх мэтчилэн хорлон сүйтгэх тохиолдол тоолшгүй болжээ. Хөгжиж байгаа улс түмэн колоничлолын хуучны тогтолцоог эвдэн төрийн тусгаар тогтнолыг байлдан олсноор баатарлаг ялалт хийжээ. Эдүгээ шинэ колоничлол, империалист зүсэн бүрийн түрэмгийллийг няцаах түүхэн зорилго дэвшигдлээ. Хөгжиж байгаа улс түмний мандалт, цэцэглэлт, энэхүү ариун, шударга эрмэлзлэлийн илэрхийлэл болсон хөгжлийн стратеги империализмд таалагдсангүй. Тэр ноёрхлоо ямар ч үнээр хамаагүй хадгална гэсэн санаагаа үйл явдлаараа илчилж байна. “Оддын дайны” төлөвлөгөөг энэ талаар иш татахад хангалттай юм.

Ж.Батмөнх “Олон улсын өнөөгийн ээдрээтэй нөхцөлд энх тайвныг сахин хамгаалж бэхжүүлэх, цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулахын төлөө шургуу тэмцэхээс илүү эрхэм зорилт үгүй”<sup>9</sup> гэж онцлон тэмдэглэжээ. Хөгжиж байгаа бүх улс түмэн хөгжлийн хэтийн саруул төлөвийн төлөө, эдийн засгийн тусгаар тогтнолын төлөө, империалист зүсэн бүрийн түрэмгийллийн эсрэг шударга тэмцлээ үргэлжлүүлж байна.

## “ТРЕТИЙ МИР”: СТРАТЕГИЯ РАЗВИТИЯ

### Резюме

Жизненно важных интересам развивающихся стран отвечает стремление далоьше не оставатьсь вне орбиты современного прогресса науки и техники. Ибо именно этого требуют неотложные задачи социально-экономического развития этих стран. Несмотря на то, что развивающенся общества еще не успели создать технико-экономический потенциал для разрешения это проблемы, все же дикетуется необходимость перейти к позитивным мерам моблизации национальных ресурсов и внешних источников для конгретных направлений перспективного развития науки и техники.

<sup>9</sup> Ж.Батмөнхийн хэлсэн үг. “Үнэн”, 1984.10.28

Заимствование всего ценного из опыта и знаний человечества, а также из различных отраслей специфического национального производства служит бесценным источником прогресса. Очевидно, народы развивающегося мира кровно заинтересованы в как можно быстрейшем сокращении большого разрыва в научно-технических уровнях между развитыми и развивающимися государствами.

Автор статьи отмечает, что только новая социальная система и научно-обоснованная стратегия развития может обеспечить быстрый темп всестороннего качественного роста этих стран.

В заключении автор статьи подчеркивает, что стратегия развивающегося мира немыслима без применения достижений науки и техники. Качественный рост развивающихся стран во многом может определяться, прежде всего, степенью внедрения современных научно-технических достижений в различные сферы экономики и культуры, образования и бытия.